

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-10
1. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал	4-9
2. Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай/	9-10
3. Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд нэмэлт оруулах тухай/	10

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
06 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 64.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 54 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Дамдинням, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Г.Уянгахишиг;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга, Э.Батшугар;
Тасалсан: Б.Дэлгэрсайхан.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын нэрийг дэвшүүлснийг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, О.Алтангэрэл, П.Сайнзориг, С.Одонтуяа, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Хууль зүйн байнгын хорооны даргад нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 5
Бүгд: 21
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар “Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав./14:18/

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд нэмэлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 26 минут үргэлжилж, 28 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооныхоо гишүүдийн мэндийг эрье. Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан эхэлж байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Хуралдаан 64,3 хувийн ирцтэйгээр ирцийн шаардлага хангагдсан байна. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дамбын Батлут, Баярмагнайн Баярбаатар, Дашдондогийн Ганбат, Одсүрэнгийн Номинчимэг, Даваахүүгийн Пүрэвдаваа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар, Саруулсайханы Цэнгүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүдийн ирцтэйгээр Мөнхбаатар гишүүн бас ирсэн байна. Ингээд ийм ирцтэйгээр хуралдаан эхэлж байна. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал байгаа.

1.Байнгын хорооны даргыг сонгох тухай

2.Дэд хорооны бүрэлдэхүүн батлах тухай /Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хороо байгуулах тухай/ асуудал байгаа

3.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрсээ өгье. Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Байнгын хорооны даргад Байнгын хорооны гишүүдийн дотроос олонхын саналаар нэр дэвшүүлнэ.” гэж заасан байдаг. Байнгын хорооны даргад нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дарга Батжаргал танилцуулна. Жигжидийн Батжаргал даргын микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга Байнгын хорооны даргаас чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө бүлэгтээ гаргасан. Энэ дагуу бид асуудлыг ярилцаад, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 26.7, 30 дугаар зүйлийн 30.1.6, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Улсын Их

Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргад Лхагвын Мөнхбаатарын нэрийг дэвшүүлж байна.

Лхагвын Мөнхбаатар Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд төрсөн. 1985-1995 онд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын 10 жилийн дунд сургууль, 1995-1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, 2006-2008 онд Отгонтэнгэр Их сургуулийг тус тус төгссөн. Хууль зүйн ухааны магистр, хуульч мэргэжилтэй.

1999-2000 онд Хууль зүйн яамны Эрх зүйн шинэтгэл стратегийн нэгдсэн төлөвлөлтийн газарт мэргэжилтэн, 2000-2006 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 2006-2008 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, 2008-2009 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга, Улсын ерөнхий байцаагч, 2009-2011 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, улсын ерөнхий бүртгэгч, 2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2013 онд Монгол Ардын намын даргын зөвлөх, 2014-2016 онд Хөвсгөл хөгжил сангийн тэргүүн, 2016 оноос одоог хүртэл 3 удаа Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар тус тус ажилласан.

Улсын Их Хурал, Засгийн газарт ажилласан байдал, мэдлэг, ур чадвар, туршлагыг нь харгалзан Лхагвын Мөнхбаатарыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна. Дэмжиж, баталж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Батжаргал гишүүнд баярлалаа. Нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Алтангэрэл, Сайнзориг гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Би асуулт бол байхгүй. Нэр дэвшигчийг дэмжиж үг хэлнэ. Өнөөдөр Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар дарга маань өөрийн хүсэлтээр Байнгын хорооны даргаасаа чөлөөлөгдөж байгаа юм байна. Оронд нь Лхагвын Мөнхбаатар гишүүн орж ирж байгааг дэмжиж байна. Өмнө нь бас Улсын Их Хурлын дэд даргаас авхуулаад бүлгийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, өмнө нь бас Хууль зүйн байнгын хорооны дарга гэсэн албан тушаалуудыг хашиж явсан. Харамсалтай нь бас улс төрийн нөхцөл байдалтай уялдуулж бас Хууль зүй, дотоод хэргийн сайдаас бол жоохон онцгүй буусан. Өнөөдөр харин энэ зүйл засагдаж, одоо бас Хууль зүйн байнгын хороог удирдахаар орж ирж байна. Энэ их зөв зүйтэй. Яагаад гэвэл энэ хүн бол салбараа мэдэж байгаа, агентлагийг удирдаж, төрийн захиргааны байгууллагыг удирдсан. Дараа нь салбарыг удирдаж бас нэлээн ажлуудыг жигдэлсэн.

Дээр нь Хууль зүй, дотоод хэргийн яам дээр өнгөрсөн хугацаанд нэлээд хуулиуд бас овоорсон байгаа. Засгийн газрын талаас өргөн барих, жишээлбэл манай Алтангэрэл гишүүний яриад байгаа тэр хөрөнгө хураах хуулиас авхуулаад Галт зэвсгийн тухай хууль, олон хуулиуд бол бас гацсан байгаа. Энийг Хууль зүйн байнгын хорооны даргын хувьд бол салбар луу бас нэлээн онцгой ач холбогдол өгч, анхаарах зайлшгүй шаардлага үүссэн юм байна. Сая орон нутгаар бас 10 хэдэн сумаараа орж, иргэдтэй уулзаж, нээлттэй санал бодол солилцож ирлээ. Иргэд энэ хуулийн хүлээлт дээр бол нэлээн бас ач холбогдол өгч асууж байна. Гол гол хуулиуд, бизнес эрхлэгчидтэй уулзахаар энэ Тендерийн хууль буюу Худалдан

авалтын тухай хуулийн асуудал гээд олон гол гол хуулиудыг бол нэлээн анхаарч байна. Тэгэхээр эдгээр зүйлүүд дээр бас шинээр сонгогдох дарга бас онцгой анхаарч, энэ нийгэмд хүлээлт үүсчихсэн байгаа хуулиудыг бас яаравчлуулах, түргэвчлүүлэх тал дээр бас онцгой анхаарч ажиллахыг бас танаас хүсье. Тэгээд амжилт хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Мөнхбаатар гишүүний хувьд бол эргэлзээ байхгүй дээ. Тэгээд ер нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийг төгсөөд, тэгээд манай Хууль зүй, дотоод хэргийн яаманд тэгээд системийн хэмжээнд олон ажлыг мерит зарчмаар явсан. Байнгын хороог ч бас удирдан чиглүүлж явсан ийм хүний хувьд бол эргэлзээ ерөөсөө алга.

Тэгэхдээ би яг өнөөдөр яг онцолж Дамдины Цогтбаатар дарга өнгөрсөн хугацаанд Хууль зүйн байнгын хороог амжилттай удирдсан гэдгийг нь дурдаж хэлмээр байна. Маш олон зүйл дээр энэ хууль сахиулах байгууллага болон энэ системийнхээ төлөө дуугарч чадаж байсан. Маш олон зүйлүүд дээр хууль, эрх зүйн шинэчлэл явах ёстой гэж үзэж ойлгож, өөрийнхөө хүч дэмжлэгээр энэ асуудлуудыг орж батлуулж байсан. Ер нь системдээ өөрийнхөө Байнгын хорооны хариуцах ажлын хүрээнд багтаж байгаа бүх байгууллагууддаа ээлтэй бас мундаг сайн ажилласан гэдгийг бас Байнгын хорооны гишүүний хувьд тодотгож хэлэхийг хүсэж байна.

Мөнхбаатар даргадаа бас манай Баярбаатар гишүүний хэлсэнтэй утга давхцаж байна. Тэгэхдээ онцгойлон хэлэхэд бид нар нийгмийн амьдралд шууд нөлөөгөө үзүүлэхүйц ийм хуулийн төслүүд Хууль зүй, дотоод хэргийн яам гээд Засгийн газар дээр байгаад байгаа. Энийг бид бас шахаж шаардаж ажиллах ёстой. Таныг ажиллаж байх үед байсан жишээлбэл нийгмийн амьдралд эдийн засгийн асуудалд болон эрүүгийн нөхцөл байдалд онцгой нөлөөлөх ач холбогдол бүхий шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл өргөн баригдчихсан байсан. Засгийн газар буцаж татаад, дахиж өргөн барина гээд одоо болтол өргөн баригдахгүй байгаа. Энэ асуудлыг хэдүүлээ намрын чуулганаар эцэслэмээр байна. Энэ маш чухал байна. Тэгээд Шүгэл үлээгчийн хууль байна, бусад зөндөө олон хуулиуд байна. Манай Засгийн газраас өргөн барихад бэлэн болчихсон, олон жил ажиллачихсан. Сая бол бүгдээрээ сайхан оролцож явж байгаад манай Хууль зүйн байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэн бүгдээрээ ажиллаж байгаад 10 жил болж байгаа, 4 парламент дамжиж байгаа энэ Гэр бүлийн хууль болон гэр бүлийн процессын хуулиудыг бас амжилттай явуулж байна. Тэгэхээр бид бол ингээд Байнгын хорооныхоо түвшинд асуудлыг яриад урагшлуулаад байх бүрэн нөөц бололцоо байна. Тийм учраас энэ асуудал дээр бас анхаарч ажиллаарай гээд. Тэгээд Цогтбаатар даргадаа өнгөрсөн хугацаанд бас энэ Байнгын хорооны үйл ажиллагааг анхны 126 гишүүн бүхий парламентын Байнгын хорооны үйл ажиллагааг маш сайн авч явсанд бас талархал илэрхийлье. Бас Мөнхбаатар даргад амжилт хүсье.

Д.Цогтбаатар: Алтангэрэл гишүүнд баярлалаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Тэгээд Одонтуяа гишүүнийг нэмчхээрэй. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би бас яг үг хэлэх гэж байсан. Алтангэрэл гишүүн хэлчихлээ. Би одоо Мөнхбаатар даргатай юу ярих вэ. Ямар анх удаа Байнгын хорооны дарга

болох гэж байгаа биш. Өмнө нь бас Хууль зүйн байнгын хорооны дарга байсан учраас бас захиж хэлээд байх ч юм байхгүй. Одоо харин зүгээр Байнгын хороо дээр байгаа жоохон юмнуудаа шахаж ажиллая. Зарим ажлын хэсгүүдийнхээ тоог гаргаад, бас яг цөөн хэдэн хүн дээр бас аймар их ажлууд овоорчихсон байна. Тэгээд энийгээ бас жигд хуваарилаад явахгүй бол юмнууд бас явахгүй байгаа шүү гэдэг зүйлийг шинэ Байнгын хорооны дарга болох хүнд бас хэлчихье.

Тэгээд гол нь Цогтбаатар даргад бас энэ 2 жилийн хугацаанд Байнгын хороогоо удирдах, Байнгын хороо дахиад доороо 2 дүү байнгын хороотой болох гэж байна. 1 нь бол уламжлалт Хүний эрхийн дэд хороо байж байгаа, дараагийнх нь бол Тусгай хяналтын дэд хороотой болох гэж байна. Тэгээд нэлээн ийм зүйлүүдийг хийж гаргаж ирэхэд манай Цогтбаатар дарга бас өөрөө анхаарсан.

2 дугаарт энэ Гэр бүлийн хуулийг хэлэлцэж батлуулах ажиллагаа дээр бас өөрөө нэлээн идэвхтэй ажиллаж байгаа. Тэгээд ийм зүйлүүд бас хийсэн шүү. Тэгээд бас Байнгын хорооны түвшиндээ боломжийн сайн ажиллалаа гэдэг зүйлийг хэлж, таны цаашдын ажилд нь бас амжилт хүсье гэж бодож байна. Энийг л хэлэх гэж байсан юм.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүнд баярлалаа. Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд Байнгын хорооны дарга нар солигдож байгаа юм байна. Тэгээд Цогтбаатар даргын хувьд бас хэдэн үг хэлье.

Өмнөх парламентад бас Цогтбаатар дарга Хууль зүйн байнгын хорооны даргаар бас ажиллаж байсан. Тэгээд ер нь ажиллах хугацаанд би бол их дэвшилтэт үзэлтэй, их сайн дарга байсан л гэж хэлэх гээд байна л даа. Яагаад гэхээр бидний нөгөө санаж бодсон чухал чухал хуулиудыг бол дандаа дэмжиж, бараг дийлэнхийг нь ингээд батлуулж өгч байсанд бас баярлалаа. Энэ парламентад бол Гэр бүлийн тухай хууль миний мэдэхийн л 4 парламент дамжсан. Тэгээд одоо энэ чинь 1999 оны хууль байх. Энийг Алтангэрэл гишүүн ахлаад, манай Байнгын хорооныхон бас вакумжаад, Байнгын хорооны манай референтүүд, мэргэжилтнүүд бүгд маш сайн ажилласан. Ингээд ямар ч байсан энэ парламентаар Монгол Улсын түүхэнд Гэр бүлийн хуулиа шинэчилсэн найруулгыг батлаад авлаа. Энэ маш чухал хууль. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль бас батлагдсан. Баасанжаргал гишүүн энэ дээр маш сайн ажилласан. Миний бас нөгөө урт настай, өмнөх парламентад унаж босоод байсан Хүний эрхийн тухай хууль, цэргийн ангиудын хууль ингээд батлагдсан. Хар тамхитай тэмцэх тухай хууль бас орж ирж байна. Ингээд манай Байнгын хороо дээр ер нь олон чухал ажлууд бас шийдэгдсэн. Тэгэхээр Цогтбаатар даргадаа бас баяр хүргэе. Тэгээд 1 сайхан алга ташчих уу.

Тэгээд Мөнхбаатар даргад бас амжилт хүсье. Тэгэхээр би Мөнхбаатар даргад юу хэлэх гэсэн юм бэ гэхээр одоо энэ чухал хуулиуд батлагдчихаар энэ хуулиудын хэрэгжилт дээр та нэг сайн анхаараад өгөөч. Жишээлэхэд Улсын Их Хурал, энэ Хууль зүйн байнгын хороо, тэр төсөв мөнгө нь байдаг бол ард иргэдэд энэ хуулиа сурталчлах ажлыг хиймээр байна. Зүгээр баталчхаад хаячихаар энэ хуулиуд чинь нэг их олигтой явахгүй, тэгээд ард иргэдэд бас ойлгуулмаар байна шүү дээ. Гэр бүлийн тухай хууль, энэ саяын хэлсэн энэ хуулиуд чинь ийм ийм чухал заалтуудыг бас ингээд батлаад, хүмүүс чинь дандаа ингээд гишүүдийг харахаар уур хүрээд байдаг биш, эд нар чинь маш чухал асуудлуудыг шийдчихсэн юм байна гэдгийг

хийхийн тулд энэ сурталчилгааны ажил дээр та нэг бас анхаарч өгөөч гэж хүсэж байна. Тэгээд энэ мансууруулах бодистой тэмцэх хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хууль дээр бид нар санаачлаад лобби бүлэг байгуулсан. Тэгэхээр энэ лобби бүлгийн ажлыг та дэмжиж өгөөд, энэ бол зөвхөн 1 яамны хийх ажил биш л юм л даа. Энэ бол бүгдээрээ л хамжиж дэмжиж байж яахгүй бол энэ бол нэлээн ноцтой түвшинд хүрсэн байгаа. Тэгээд энэ асуудлыг та бас өмнө нь нөгөө СЭМҮТ-ийн хашаанд баригдах төвийн зураг төслийн мөнгийг бас шийдэж өгч байсан. Тэгэхээр энэ ажлуудаа та сайн явуулаад өгөөч ээ гэж л хүсэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүнд баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дуусаж байна. Би Мөнхбаатар даргад бас хэдэн зүйл хэлмээр байна.

Мөнхбаатар дарга Байнгын хороог урьд нь бас удирдаж байсан. Ер нь Хууль зүйн сайд байсан. Яг энэ салбарын бол ёстой уугуул мэргэжилтэй, энэ салбарын хүн. Тэгээд Байнгын хороог удирдах болж байгаад би их баяртай байна. Миний хувьд бол аливаа ажил, төрийн ажил бол өөр ийм дэс дугаартай, хугацаа хязгаартай байдаг. Та бүгдийнхээ итгэл дэмжлэгээр 2023 онд өмнөх парламентын үед Байнгын хорооны дарга хийсэн. Шинэ парламентын үед жилээр ротацтай томилогддог ч гэсэн би 2 удаа та бүгдийнхээ дэмжлэгийг авч, шинэ парламентын үед Байнгын хорооны дарга хийлээ. Одоо тэгээд дараагийн даргадаа энэ ажлаа өгөөд явах нь бол зүй ёсны хэрэг гэж үзэж, би өөрийнхөө саналаар ажлаа өгч байгаа.

Байнгын хорооныхоо гишүүдэд би харин ёстой онцгой талархал илэрхийлмээр байна. Яагаад гэвэл энэ хугацаанд та бүгд маань өөрсдөө бас яг нөгөө ажилдаа бид нар давтаад л тэр болгон анзаарахгүй явж байж магадгүй. Хууль зүйн 3 дахь сайдаа үзэж байгаа. Байнгын хороо байрандаа л байж байгаа. Тэгэхээр энэ хууль зүйн салбарын бодлого гэдэг юмыг чинь ер нь бол Монгол Улсын бодлогыг Их Хурал тодорхойлдог, парламентын засаглалтай улс. Тэгэхээр тэр бодлогын тогтвортой байдлыг Их Хурал хангаж өгөөд, энэ дотроо хамгийн тэргүүн эгнээнд нь манай Байнгын хороо явж байсан. Тэгээд Байнгын хорооны хүрээнд хийж байсан ажлаар хамгийн наад зах нь гэхэд нөгөө шүүхийн индекс 51 хувь байж байгаад, одоо 57 хувьд хүрчихсэн. Энд 1 нэгжээр хөдөлгөх маш хэцүү ажил байдаг. Яагаад гэвэл шүүхэд итгэх итгэл олон нийтийн дунд тухайн үед ямар байсан билээ. Бүгдээрээ л шүүх дээр очоод асуудал гацаад байна, ингээд байна гээд л иргэд ярьдаг байсан бол энэ Байнгын хорооны зүгээс бид нар сэтгэл нэгтэйгээр маш олон асуудлыг шийдэж өгсөн. Шүүхийн ил тод байдлыг хангаж өгөх чиглэлээр хуулийг нь баталж өгөөд, одоо энэ Дээд шүүхийн бүх хуралдаан чинь live stream line-аар явж байгаа. Гаднын зарим юунууд хүрч ирээд, танайх энэ дээрээ маш том ахиц гаргачихсан байж байгаа юм байна шүү дээ. Энд чинь хаалттай 1 ч асуудал байдаггүй юм байна шүү дээ гээд яриад явсан байна лээ. Эртээд би гаднын нэг төлөөлөгчтэй уулзсан. Надад өөрөө орж ирээд энийг ярьж байна лээ. Тэгэхээр энэ дээр энэ ахиц гаргахад бол та бүгдийн хүчин чармайлтын дэмжлэг маш чухал байсан.

ЭХХШТХ-тай холбогдуулаад бид нар нэлээн олон өөрчлөлтүүд оруулсан. Одоо ингээд шүүх дээр тэр мэтгэлцээн явуулах нөхцөл байдал хамаагүй сайжирчихсан. Энэ дээр өмгөөлөгчдийн эрхийг бид нар нэлээн сайн хангаж өгсөн. Өмгөөлөгчийн эрхийг бид нар хангаж өгнө гэдэг иргэнийхээ талд, төрийнхөө талд биш, прокурор цагдаагийн талд биш, иргэнийхээ талд бид нар илүү гарч өгч тэр өмгөөлөгчийн эрхийг бэхжүүлж өгч, нотлох баримттай танилцах хугацаа бүх юман дээр нь бид нар онцгой анхаарч ажилласан. Энэ дээр бас бодит үр дүн гарч байгаа. Өмгөөлөгч нар та бүгдэд ч гэсэн ирээд хэлж байгаа байх. Энэ дээр бол бодит өөрчлөлт гарч байгаа шүү. Тэгээд энэ одоо нэгэнт эхлээд энэ зүг чиг рүүгээ яваад

эхэлж байгаа энэ өөрчлөлтүүд бол цаашаа үргэлжлээд явна. Мөнхбаатар дарга маань энийг амжилттай хийж чадна гэж би итгэж байгаа. Тэгээд Мөнхбаатар даргадаа бас ажилд нь амжилт хүсье.

Харин түрүүн Одонтуяа гишүүн алга ташъя гэсэн, би гишүүддээ алга ташмаар байна. Та нар мундаг шүү. Баярлалаа.

Ингээд одоо санал хураалт явуулъя. Гишүүд үг хэлж дууслаа.

Хууль зүйн байнгын хорооны даргад нэр дэвшигч Лхагвын Мөнхбаатарыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалт дэмжье гэсэн томьёоллоор. 76,2 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна.

14.13 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

“Дэд хорооны бүрэлдэхүүн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. /Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хороо/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 “дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэх бөгөөд нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн дэд хорооны бүрэлдэхүүний тухай тогтоол батална.” гэж заасан байгаа.

Ингээд дэд хорооны бүрэлдэхүүнд орохоор намын бүлгүүдээс ирүүлсэн нэрсийг уншиж танилцуулъя.

Монгол Ардын намын зүгээс Дамдины Цогтбаатар, Баярбаатар гишүүн, Соронзонболд гишүүн гэсэн ийм 3 гишүүний нэр ирүүлсэн байна.

Ардчилсан намаас 2 гишүүний нэр ирүүлсэн байгаа. Тэмүүжин, Шижир гээд. Шижир гишүүн манай Байнгын хороонд юу орно гэж байгаа. Тэгэхээр яг одоо бол нөгөө Байнгын хорооны гишүүдээсээ байгаа учраас бүлгээс ирсэн саналуудыг бол хүндэтгэж хүлээж авч байна. Тийм учраас яг санал хураахад бол Тэмүүжин гишүүнийг л оруулж батлах боломжтой байна. Тэрний дараа процедурын дагуу Шижир гишүүн тэгээд нөхцөл нь бүрдэхээр орж ирэх байх. Ингээд дэд хорооны бүрэлдэхүүний талаар асуулт асуух гишүүд байна уу.

Тэгвэл Цогтбаатар гишүүн ер нь горимын санал гаргачих. Тэгээд санал хураачихъя. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ Тусгай хяналтын дэд хороо гэж Хууль зүйн байнгын хороо дээр шинээр байгуулагдаж байгаа дэд хороо дээр аль намын одоо Монгол Ардын нам ч тэр, Ардчилсан нам ч тэр намын бүлэг дээрээ нарийвчилж, мэргэжлийн хүмүүсээ тухайлан сайн ярилцах ёстой гэсэн байр суурь илэрхийлж байна. Аль, аль намын гишүүд маань. Тэгэхээр энийг хэлэлцэх

асуудлаас хойшлуулж, бүлгүүд хэлэлцсэний дараа хэлэлцье гэдэг ийм горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Ингээд асуудлыг хойшлуулъя гэдэг горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Тэгэхлээр энэ асуудлыг хойшлууллаа. Дараагийн хурал хүртэл.

14.18 цаг.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны төсөл 3 дахь асуудлаа хэлэлцье.

Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 2026 оны дугаар өдөр, дугаар. Улаанбаатар хот.

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Хууль зүйн бай байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Д.Ганбат нарыг тус тус нэмсүгэй.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар.

Тэгээд бид нар урьд нь байгуулчихсан, одоо энэ 2 гишүүн нэмж оръё гэсэн юм. Асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Ингээд “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Манайхан бэлдээрэй. Санал хураалт. 71,4 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа. Бүгдэд нь амжилт хүсье.

14.20 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ